



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2006 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 113

Улаанбаатар

Гадаадад суралцуулах тухай

2004-2005 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2004 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн болон 2003 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хурлын тэмдэглэл, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын 2,6-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баделхан овогтой Галияг Англи улсын Лондон хотын Худалдааны сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Чулуунбат овогтой Оюунбилэгийг Англи улсын Дурхам бизнесийн сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр тус тус 2 жилийн хугацаагаар 2006-2007 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

*Баделхан баделхан овогтой Галияг Англи улсын Лондон хотын Худалдааны сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар 2006-2007 оны хичээлийн жилээс суралцуулсугай.*

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2004 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 315 дугаар тушаалын Б.Галиятай холбогдолтой хэсгийг, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 231 дүгээр тушаалын Ч.Оюунбилэгтэй холбогдолтой хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2004-515, 2005-221



*Ө.Энхтүвшин*

Ө.ЭНХТҮВШИН

0002371